



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтад заавал бүрдүүлж ирэх материал:

- ❖ Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- ❖ Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрд нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг хийлгэсэн байна.

Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн “УЦУОШТөвийн барилгын дотор засварын” 1 давхар блокон болон чулуун барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. Дээрх ажлыг

гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөл (Зураг төслийн шифр: TL-02/24), 2024 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн дугаар 701/2024 магадлалын дүгнэлттэй зураг төсвийн дагуу мөн стандарт, технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтад оруулна.

УЦУОШТөвийн барилгын ажилд:

Барилгын угсралтын ажил гүйцэтгэх явцад барьцалдуулах зуурмаг, шавардлага зэрэгт туршилт, сорилт, хяналт шалгалтыг талбай дээр ажлыг хийж гүйцэтгэж байх хугацаанд байвал зохино. Барилгад бүх материал нь улсын стандартад нийцсэн материал сонгосон байх шаардлагатай.

Нэмэлт тайлбар :

Барилгын А блоконд хийгдэх ажил

- ✓ Угсармал ламинатан шал шахаж хийх /2, 3 тоот өрөө/
- ✓ Эко хавтанцраар ханан дээр өнгөлгөө хийх /2, 4, 5, 6 тоот өрөө/
- ✓ Боржин чулуун хавтан дэвсэж шал хийх /4, 5, 6 тоот өрөө/
- ✓ Хөнгөн цагаан рамтай 60х60 хэмжээтэй дүүжин таазыг хавчаар ба төмөр утсаар зүүх /4, 5, 6 тоот өрөө/
- ✓ Уналттай тааз хийх /3 тоот өрөө/
- ✓ Цонх солих
- ✓ Акустик буюу эсгий хавтангаар доторлогоо хийх /3 тоот өрөө/

Барилгын Б блоконд хийгдэх ажил

- ✓ Угсармал ламинатан шал шахаж хийх /3, 4, 5, 6, 9, 10, 11 тоот өрөө/
- ✓ Эко хавтанцраар ханан дээр өнгөлгөө хийх /2 тоот өрөө буюу коридор/
- ✓ Боржин чулуун хавтан дэвсэж шал хийх /2 тоот өрөө буюу коридор/
- ✓ Хөнгөн цагаан рамтай 60х60 хэмжээтэй дүүжин таазыг хавчаар ба төмөр утсаар зүүх /2, 6 тоот өрөө/
- ✓ Уналттай тааз хийх /3, 4, 5, 9, 10, 11 тоот өрөө/

- ✓ Цонх солих
- ✓ Үүдний гонхонд хаалга хийх /2 ширхэг/
- ✓ Акустик буюу эсгий хавтангаар доторлогоо хийх /3, 4, 5, 6, 9, 10, 11 тоот өрөө/

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна” гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын засварын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Зураг төсвийн зардал болох 6.091.720 /зургаан сая ерэн нэгэн мянга долоон зуун хорин төгрөг/ ажлыг хасаж тооцно.

Магадлашгүй ажлыг зардлыг хэрхэн ямар ажилд зарцуулах талаар захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжүүлж байгаа байгууллага болон хяналтын инженерт танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу Ус цаг уур орчны шинжилгээний төвд гаргана. Зөвшөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно.

Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

БОЛОВСРУУЛСАН:

УЦУОШТӨВИЙН ЦАГ УУР ОРЧНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА *Мөнхбаяр* Н.МӨНХБАЯР